

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/148/НА-СТА-ТӨҮГ

ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70272248 Цахим хаяг: [nyamsuren@audit.gov.mn](mailto:nyamsuren@audit.gov.mn)



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100. Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582. Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

Мэд. Об. 25 № 01/38  
тавай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА А.НЯМСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Гарын бэлэг 790.0 мянган төгрөг, халуун вино 70.5 мянган төгрөг нийт 860.5 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл болон согтууруулах төрлийн бараа худалдан авсан;
- Ажилчдын гутал 516.0 мянган төгрөгөөр худалдан авч төсвийг зориулалт бус зарцуулсан;
- Шаардлагагүй хүнсний материал, мах, гурил авахад 4,104.6 мянган төгрөг зарцуулсан;
- Тайлант онд 3 иргэн, 5 аж ахуй нэгжээс нийт 4,100.0 мянган төгрөгийн хандив авсан, тайланд тусгаж зарцуулалтыг тайлагнаагүй;

Зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8, Хувь хүний орлогын татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 22 дугаар зүйлийн 22.1.1-д заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн

412505332

тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 21 орон тоо батлагдсанаас удирдах 5 , төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх 12, төрийн үйлчилгээний гүйцэтгэх 4 нийт 21 орон тоотой ажилласан байна.

#### **Аудитын гол асуудал**

Төв аймгийн Аргалант суманд тохиолдсон цас зуд, байгалийн давагдашгүй хүчин зүйлд зориулж иргэдээс хандиваар 6,700.0 мянган төгрөг, ХХААГ-аас 79,476.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 48,000.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 6,001.0 мянган төгрөгийн шатахуун, 7,060.0 мянган төгрөгийн хүнс, малын тэжээл нийт 147,237.8 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө болон бараа материал ирүүлснийг бүртгэлд тусган тайлагнасан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт, 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэлээр 86,0 хувийн биелэлттэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	204,156,112.06	248,338,335.20
33	АВЛАГА	109,040,500.00	127,555,413.04
335	Бусад авлага	109,040,500.00	127,555,413.04
3351	Байгууллагаас авах авлага	109,040,500.00	127,555,413.04
35	БАРАА МАТЕРИАЛ	95,115,612.06	120,782,922.16
354	Хангамжийн материал	91,615,612.06	117,282,922.16
35410	Бичиг хэргийн материал	2,012,100.00	1,301,450.00
35420	Аж ахуйн материал	15,193,639.00	21,799,649.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,984,000.00	17,819,000.00
35440	Түлш, шатах тослох материал	159,300.00	47,800.00
35450	Барилгын засварын материал	2,472,290.00	2,472,290.00
35600	Мал амьтад	3,500,000.00	3,500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,435,882,962.88	2,612,845,264.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,435,882,962.88	2,612,845,264.27
392	Биет хөрөнгө	1,783,353,796.13	1,953,752,097.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,439,702,091.26	2,509,937,811.26
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,068,848,739.98)	(1,115,486,775.32)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	257,848,032.00	282,968,032.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(129,903,274.65)	(129,731,366.29)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	654,377,849.73	747,632,799.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	(474,050,458.05)	(498,201,586.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	82,405,916.00	96,905,916.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(60,449,683.86)	(64,472,404.76)
39209	Зам, гүүрийн байгууламж	41,000,000.00	41,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(41,000,000.00)	(41,000,000.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	337,094,660.00	412,332,420.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(254,822,596.32)	(288,132,748.91)
393	Биет бус хөрөнгө	652,529,166.75	659,093,166.79
39301	Програм хангамж	3,510,000.00	10,510,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,214,833.25)	(3,650,833.21)
39303	Бусад биет бус хөрөнгө	652,234,000.00	652,234,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,640,039,074.94	2,861,183,599.47
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,148,056.17	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,148,056.17	-
413	Өглөг	1,148,056.17	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	65,486.40	-
4136	Бусад өглөг	1,082,569.77	-
41361	Байгууллагад төлөх өглөг	1,082,569.77	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,638,891,018.77	2,861,183,599.47
51	Засгийн газрын хувь оролцоо	2,638,891,018.77	2,861,183,599.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,377,154,433.19	1,377,154,433.19
51101	Өмч: - төрийн	1,377,154,433.19	1,377,154,433.19
512	Хуримтлагдсан үр дүн	1,119,319,265.90	1,341,611,846.60
51210	Өмнөх үеийн үр дүн	1,119,319,265.90	1,119,319,265.90
51220	Тайлант үеийн үр дүн	-	222,292,580.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	142,417,319.68	142,417,319.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,640,039,074.94	2,861,183,599.47

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Дансны код	Үзүүлэлт	төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	856,332,416.90	1,561,963,540.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,841,399.00	190,923,470.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,841,399.00	190,923,470.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,841,399.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16,841,399.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	839,491,017.90	1,371,040,070.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	149,801,817.90	239,395,170.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	6,700,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	91,768,620.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	149,801,817.90	117,903,910.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	23,022,640.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	689,689,200.00	1,131,644,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	689,689,200.00	1,131,644,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	885,595,920.85	1,339,670,959.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	793,947,136.85	1,283,667,241.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	742,669,310.98	1,015,922,028.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	346,076,449.26	551,644,125.34
210101	Үндсэн цалин	239,087,959.61	320,050,055.03
210102	Нэмэгдэл	75,037,081.65	214,922,830.31
210104	Урамшуулал	31,951,408.00	16,671,240.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,790,775.57	68,606,361.69
210201	Тэтгэврийн даатгал	34,398,673.93	47,716,260.73
210202	Тэтгэмжийн даатгал	3,429,582.05	5,752,684.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,748,046.40	2,896,638.79
210204	Ажилгүйдлийн даатгал	557,800.08	2,528,750.73
210205	Эрүүл мэндийн даатгал	5,656,673.11	9,712,026.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,836,237.77	88,760,980.87
210301	Гэрэл, цахилгаан	8,244,069.77	7,168,980.87
210302	Түлш, халаалт	81,592,168.00	81,592,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,571,345.20	35,433,965.00
210401	Бичиг хэрэг	6,978,770.00	4,895,940.00
210402	Тээвэр, шатахуун	26,090,475.20	28,345,225.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,502,100.00	2,192,800.00
2105	Нормативт зардал	1,832,800.00	2,472,000.00
210502	Хоол, хүнс	1,832,800.00	2,472,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,474,109.70	3,072,000.00
210602	Тавилга	2,292,109.70	-
210604	Урсгал засвар	3,182,000.00	3,072,000.00
2107	Томиллолт, зочны зардал	5,436,400.00	6,334,000.00

210702	Дотоод албан томилолт	5,436,400.00	6,334,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,404,173.00	4,314,690.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,855,694.00	3,971,290.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	233,068.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	266,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	315,411.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	77,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	208,247,020.48	255,283,905.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,431,582.00	121,825,977.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	187,815,438.48	133,457,928.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,277,825.87	267,745,212.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	25,012,155.08
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	5,425,104.08
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	18,587,051.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	50,277,825.87	242,733,057.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,277,825.87	242,733,057.81
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	91,648,784.00	56,003,717.90
2200	Дотоод эх үүсвэрээр	91,648,784.00	56,003,717.90
221001	Их засвар	40,809,000.00	7,500,000.00
222001	Тоног төхөөрөмж	3,799,800.00	-
223001	Бусад хөрөнгө	47,039,984.00	48,503,717.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(29,263,503.95)	222,292,580.70
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(29,263,503.95)	222,292,580.70

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	839,491,017.90	1,371,040,070.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	839,491,017.90	1,371,040,070.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	149,801,817.90	239,395,170.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	6,700,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	91,768,620.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	149,801,817.90	117,903,910.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	23,022,640.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	689,689,200.00	1,131,644,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	689,689,200.00	1,131,644,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	672,846,637.20	1,143,321,222.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	672,846,637.20	1,143,321,222.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	621,568,811.33	874,393,113.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	348,614,556.26	550,827,481.89
210101	Үндсэн цалин	228,419,748.06	300,607,695.77
210102	Нэмэгдэл	92,819,530.96	232,886,126.30
210104	Урамшуулал	27,375,277.24	17,333,659.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,245,675.17	68,714,145.86
210201	Тэтгэврийн даатгал	30,088,299.26	47,742,666.32
210202	Тэтгэмжийн даатгал	3,555,817.00	5,619,816.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,925,929.29	2,834,164.68
210204	Ажилгүйдлийн даатгал	711,085.00	2,496,308.93
210205	Эрүүл мэндийн даатгал	6,964,544.62	10,021,189.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,423,668.00	90,123,550.64
210301	Гэрэл, цахилгаан	7,161,500.00	8,251,550.64
210302	Түлш, халаалт	81,592,168.00	81,592,000.00
210303	Цэвэр, бохир ус	670,000.00	280,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,614,603.00	26,275,185.00
210401	Бичиг хэрэг	2,177,860.00	2,978,640.00
210402	Тээвэр, шатахуун	8,789,600.00	19,041,485.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,223,920.00	2,172,150.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,423,223.00	2,082,910.00

2105	Нормативт зардал	-	516,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	516,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,300,000.00	9,753,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,410,800.00
210604	Урсгал засвар	2,300,000.00	7,342,250.00
2107	Томилолт, зочны зардал	5,436,400.00	6,334,000.00
210702	Дотоод албан томилолт	5,436,400.00	6,334,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,556,680.00	8,182,903.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,066,694.00	7,489,503.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	233,068.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	266,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	256,918.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	77,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,377,228.90	113,666,797.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	108,377,228.90	113,666,797.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,277,825.87	268,928,108.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	26,195,050.80
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	6,607,999.80
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	18,587,051.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	50,277,825.87	242,733,057.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,277,825.87	242,733,057.81
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	166,644,380.70	227,718,848.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	166,644,380.70	227,718,848.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	166,644,380.70	227,718,848.00
2200	Дотоод эх үүсвэрээр	166,644,380.70	227,718,848.00
221001	Их засвар	20,678,649.00	7,500,000.00
222001	Тоног төхөөрөмж	3,380,000.00	86,900.00
223001	Бусад хөрөнгө	19,749,676.00	107,424,188.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	122,836,055.70	112,707,760.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,377,154,433.19	142,700,176.79	-275,801,510.72	1,244,053,099.26
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,377,154,433.19	142,700,176.79	-275,801,510.72	1,244,053,099.26
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,584,011,387.67	1,584,011,387.67
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,377,154,433.19	142,417,319.68	1,148,582,769.85	2,668,154,522.72
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,377,154,433.19	142,417,319.68	1,148,582,769.85	2,668,154,522.72
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,377,154,433.19	142,417,319.68	1,148,582,769.85	2,668,154,522.72
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-29,263,503.95	-29,263,503.95
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,377,154,433.19	142,417,319.68	1,119,319,265.90	2,638,891,018.77

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Залруулагдаагүй нийт 422,841.2 мянган төгрөгийн зөрчлөөс 11,439.8 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5,112.0 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 760,818.2 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 190,923.5 мянган төгрөгийг үндсэн хөрөнгө, бараа материалаар салгаж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд төсөвт буцаан төвлөрүүлсэн 242,733.1 мянган төгрөгийг тохируулга хийж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан мал угаах төхөөрөмж 48,000.0 мянган төгрөгийн машиныг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн гэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4. Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 79,476.8 мянган төгрөгийн тэжээлийн хадуурыг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн гэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5. Санхүүгийн тайлангийн уялдааг шалгахад 156,804.8 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6. Тайлант онд сургуулийн дотуур байрны цонхны 20,000.0 мянган төгрөгийг Засаг даргын Тамгын газар дээр орлогод авсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

7. Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд 22,880.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгслийг актлах тушаалгүй акталж устгасан гэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 426,941.2 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 5,035.2 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 8,204.6 мянган төгрөгийн 3 албан шаардлага өгч, 415,501.4 мянган төгрөгийн 6 зөвлөмж хүргүүлээ.

### **5.1 Төлбөрийн акт**

1. Тайлант онд тушаал шийдвэргүй гарын бэлэг 790.0 мянган төгрөг, халуун вино 70.5 мянган төгрөг нийт 860.5 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл болон согтууруулах төрлийн бараа худалдан авсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-т “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;”, 15 дугаар зүйлийн 15.1.7-д “байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд тушаал шийдвэргүй ажилчдын гутал 516.0 мянган төгрөгөөр худалдан авч төсвийг зориулалт бус зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

---

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3. Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу 3 албан хаагчид 18,587.1 мянган төгрөг олгосон байна. Дээрх урамшууллаас ХХОАТ 1,858.7 мянган төгрөгийг суутгаж, төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "Хариуцлагатай байх", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсхүл төвлөрүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

## **5.2 Албан шаардлага**

1. Тус байгууллага тайлант онд шаардлагагүй хүнсний материал, мах, гурил авахад 4,104.6 мянган төгрөг зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.4-д "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

2. Тайлант онд 3 иргэн, 5 аж ахуй нэгжээс нийт 4,100.0 мянган төгрөгийн хандив авсан, тайланд тусгаж зарцуулалтыг тайлагнаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 25 дугаар зүйлийн 25.2-т "Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

3. ЖДҮ хариуцсан мэргэжилтэн Л.Отгон нярав хавсарч байгаа зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6-д "Энэ хуульд заасан журмыг зөрчиж, төрийн албан

хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэхийг хориглоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Авлага данстай холбоотой асуудал**

##### **Илрүүлэлт:**

Тус байгууллага нь тайлант онд 127,555.4 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **Өгсөн зөвлөмж:**

Цаашид төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

#### **2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

##### **Илрүүлэлт:**

Тус байгууллага нь 1,216.9 мянган мкв талбайтай 20 газартай ба нийт 929,994.0 мянган төгрөгийн дүнтэй газруудаа бүрэн гүйцэд орлогод аваагүй, данс бүртгэлд тусгаагүй 277,760.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;”, Сангийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 207 дугаар тушаалаар баталсан “Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах тухай аргачлал”-ыг гэсэн болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **Өгсөн зөвлөмж:**

Цаашид биет бус хөрөнгө болох газрыг бүрэн гүйцэт орлогод авч, нэгжийн талбар болон дүн зөрүүтэй зөрчлийг арилгах.

#### **3. Шилэн данстай холбоотой асуудал**

##### **Илрүүлэлт:**

Тус байгууллага нь Шилэн дансанд мэдээлбэл зохих 183 мэдээллийг мэдээлэхээс 12 мэдээлэл хугацаа хоцроосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Шилэн дансны зарчим”-ыг гэсэн болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **Өгсөн зөвлөмж:**

Цаашид Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь оруулах.

#### **4. Үндсэн хөрөнгө данстай холбоотой асуудал**

##### **Илрүүлэлт:**

Тайлант онд Монголын баялаг өв соёл кино контентод 3,876.0 мянган төгрөгийг зарцуулж, орлогод аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, гэсэн болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Биет бус хөрөнгөөр орлогод авах.

5. Зардлын данстай холбоотой асуудал

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр тавилга эд хогшил 13,000.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 12,000.0 мянган төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр тавилга эд хогшил 1,500.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 3,970.0 мянган төгрөг нийт 5,470.0 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу худалдан авалт хийх.

6. Зардлын данстай холбоотой асуудал

Тус байгууллага нь тайлант онд Шагайн харвааны тэмцээнд 280.0 мянган төгрөг, Шатрын тэмцээнд 350.0 мянган төгрөг, дартсын тэмцээнд 210.0 мянган төгрөг нийт 840.0 мянган төгрөгийг тэмцээн уралдаанд зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн болон санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид төсвийн хөрөнгөөр тэмцээн уралдаан зохион байгуулах зардлыг багасгах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 04 дугаар сарын 15-ны дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажилчдын гутал авсан	1	516.0	1	516.0				
Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу 3 албан хаагчид 18,587.1 мянган төгрөг олгосон байна. Дээрх урамшууллаас ХХОАТ 1,858.7 мянган төгрөгийг суутгаж, төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.	1	1,858.7	1	1,858.7				
Бэлэг, дурсгалын зүйл болон согтууруулах төрлийн бараа худалдан авсан	1	860.5	1	860.5				
Хүнсний материал, мах, гурил авсан	1	4,104.6			1	4,104.6		
ЖДҮ хариуцсан мэргэжилтэн Л.Отгон нярав хавсарч байгаа зөрчил илэрлээ.	1	0			1	0		
Тайлант онд 3 иргэн, 5 аж ахуй нэгжээс нийт 4,100.0 мянган төгрөгийн хандив авсан, тайланд тайлагнаагүй зөрчил илэрлээ.	1	4100.0			1	4100.0		
Тус байгууллага нь 20 газартай ба нийт 929,994.0 мянган төгрөгийн дүнтэй газруудаа бүрэн гүйцэд орлогод аваагүй, данс бүртгэлд тусгаагүй, нэгжийн талбар, 277,760.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	277,760.0					1	277,760.0
Тайлант онд 127,555.4 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага үүсгэсэн байна.	1	127,555.4					1	127,555.4
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэтрүүлэн тавилга эд хогшил 1,500.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 3,970.0 мянган төгрөг нийт 5,470.0 мянган төгрөгөөр тус тус зарцуулсан байна.	1	5,470.0					1	5,470.0
Тайлант онд Монголын баялаг өв соёл кино контентод 3,876.0 мянган төгрөгийг зарцуулж, орлогод аваагүй байна.	1	3,876.0					1	3,876.0
Тайлант онд тус байгууллага нь Шагайн харвааны тэмцээнд 280.0 мянган төгрөг, Шатрын тэмцээнд 350.0 мянган төгрөг, дартсын тэмцээнд 210.0 мянган төгрөг нийт 840.0 мянган төгрөгийг тэмцээн уралдаанд зарцуулсан байна.	1	840.0					1	840.0
Тайлант оны шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 183 мэдээллийг мэдээлэхээс 12 мэдээлэл хугацаа хоцроосон байна.	1	0					1	0
<b>Дүн</b>	<b>12</b>	<b>426,941.2</b>	<b>3</b>	<b>3,235.2</b>	<b>1</b>	<b>8,204.6</b>	<b>6</b>	<b>415,501.4</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТӨҮГ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум  
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр  
Утас: +976 70272582, +976 70273204  
И –мэйл: [tuv@audit.gov.mn](mailto:tuv@audit.gov.mn), Вебсайт: [www.audit.mn](http://www.audit.mn)